



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 1142

Чойр

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн 01 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тайланд улсын Бангкок хотноо зохион байгуулагдах “Сурагчдын Азийн аврага” шалгаруулах тэмжээнд Говьсүмбэр аймгийн усан спортын холбооны 10 тамирчин, 1 дасгалжуулагч багш Монгол улсыг төлөөлж оролцох болсон тул тэмцээний зардалд 2,000,000 (хоёр сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Содном)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТСУУРЬ